

ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЭЛ-ШҮҮХ

Уиллем Корталс Алтес Хуульч, ОХУ-ын Воронеж хотын "Хэвлэл мэдээллийг хамгаалах төв"-ийн гүйцэтгэх захирал

Сэтгүүлч бичсэн нийтлэлдээ:

1. Хэн нэгэн хvний нэр төрийг гутааж, гомдоосон vг хэрэглэсэн байвал
2. Хэн нэгний тухай худал мэдээлэл бичсэн байвал (vнэн биш баримт хэрэглэсэн)
3. Үнэн мэдээллийг бичсэнээрээ хэн нэгний хувийн нууцыг задруулсан байвал /хичнээн vнэн байсан ч олон нийт хэн нэгний талаар заавал бvх зvйлийг мэдэж байх албагvй/ эдгээрийн дагуу шvvxэд нэхэмжлэл ирж болно.

Шvvx vvнийг цэгнэж vзэхдээ:

1. Хэн нэхэмжлэл гаргаж байна вэ гэдгийг маш сайн анхаарах хэрэгтэй. Үvнд:
 - Гомдол гаргаж байгаа хvн нь epee амьд байж нэр төрөө сэргээлгэхээр нэхэмжлэл гаргах ёстой. Харин хэн нэгэн нас барсан хvний epee гомдол гаргаж болохгvй.
 - Нэхэмжлэл гаргагч нь жирийн иргэн байх ёстой. Хуулийн этгээд байх ёсгvй.
2. Ямар хvн нэхэмжлэл гаргаж байна вэ гэдгийг анхаарах хэрэгтэй. Үvнд:
 - Жирийн иргэн байж болно.
 - Олны танил, нэртэй хvмvvc байж болно. Үvнд улс төрчид, нэртэй одод, дуучид, жvжигчид, нийгэмд эзэлж байгаа байр суурь, хэргэм зэрэг, албан тушаалаасаа болоод олны нvдэнд байнга ертеж байдаг хvмvvc ордог. Жишээлбэл, манай улсын хувьд хааны гэр бvлийн гишvвд байна. Тэднийг хvмvvc сонгодоггvй, тэд ч eepcдийн хvслээр хааны гэр бvлийн гишvвн болоогvй. Зvгээр л тэгээд төрчихсөн. Гэвч олон нийт тэдний тухай нийтлэл гарахад маш их сонирхон уншдаг. Тийм учраас эдгээр хvмvvc нь хvссэн хvсээгvй олон нийтийн epee ил байдаг. Гэхдээ тэднийг eepcдийн хvслээр олон нийтийн epee гарч ирсэн хvмvvcээс ялгаж салгаж ойлгох хэрэгтэй. Жишээлбэл, улс төрчид, киноны нэртэй жvжигчид зэрэг нь eepcдийн сонголтоор гарч ирсэн хvмvvc юм.

Тэгвэл яагаад жирийн иргэн, олны танил алдартай хvн хоёрыг ялгаатай авч vзэх шаардлагатай байдаг вэ? Манайд “Ендер мод салхинд илvv ертдэг” гэдэг vг байдаг. Epeeep хэлбэл, хvн хэдий чинээ нэр алдартай байна, төдий чинээ олны хараанд ертемгий байна. Энэ нь нийгэмд ендер байр суурь эзэлж байгаа хvмvvc жирийн иргэдийг бодвол илvv хариуцлага хvлээж, янз бvрийн мэдээллийг хvлээж авахад илvv бэлэн байх ёстой гэсэн vг юм. Энэ бол Европын орнууд болон Европын хvний эрхийн шvvxийн баримталдаг гол зарчмуудын нэг. Нэгэнт олон нийтийн epee ил гарч ирсэн хvмvvc eepcдийнх талаар бичсэн зvйлийг хvлээн авах чадвартай, шvvmжлэлд тэвчээртэй ханддаг байх ёстой. Энэ бол маш чухал зvйл юм. Европд олонд нэртэй, ендер албан тушаалд байгаа хvмvvc шvvxэд маш бага нэхэмжлэл гаргадаг. Учир нь тэд нөхцөл байдлаа сайн ойлгосон байдаг. Жишээ болгож нэг тохиолдлыг ярья. Үvнийг Лингинсийн хэрэг гэж нэрлэдэг. Австрийн сэтгүүлч Лингинс улсынхаа Канцлерийг хоёр ч удаа шvvmжилж бичжээ. Яагаад гэвэл тэр Канцлер нь дэлхийн 2-р дайны вeд Германы талд байсан нэгэн улс төрчийг дэмжсэн байжээ. Гэтэл Австрийн шvvx сэтгүүлчийг буруутгаж, “хэдийгээр энэ нийтлэлд худал мэдээлэл байхгvй ч, бас vнэн гэдэг нь нотлогдоогvй” гэж хэлсэн. Ингээд Австрийн хуулиар сэтгүүлч бичсэн зvйлийнхээ vнэн зевийг заавал нотлох шаардлагатай байдаг учраас шvvx Лингинсийг буруутай гэсэн шийдвэр гаргасан. Гэвч энэ хэрэг Европын хvний эрхийн шvvx дээр ирээд эсрэгээр шийдэгдсэн. Европын шvvx: “Хэвлэл

мэдээллийн эрх чөлөө нь олон нийтэд улс төрийн удирдагчдын талаарх өөрийн гэсэн үзэл бодлыг бий болгох боломжийг олгодог. Улс төрийн маргаан бол ардчилсан нийгэмд маш чухал зүйл юм. Улс төрч хүний хувьд жирийн иргэдийг бодвол шvvмжлэлд ертөх хүрээ нь маш ергөн байдаг. Тийм учраас тэд шvvмжлэлд тэвчээртэй байх ёстой” гэж үзээд, дээрх сэтгvvлчийг зөвтгөсөн байна.

3. Нийтлэлд бичсэн мэдээлэл бодит үнэнд нийцэхгvй байвал:

- Сэтгvvлчээс үүнийг бичиж байхдаа үнэн, худлыг нь мэдэж байсан эсэхийг шvvх асууж тодруулах ёстой. Хэрэв худлаа гэдгийг нь мэдсээр байж нийтлvvлсэн бол сэтгvvлчид илvv хариуцлага тооцно. Хэрэв мэдээгvй байсан бол бичсэн мэдээллээ батлахын тулд юу хийсэн, ямар хүчин зvтгэл гаргасан, давхар хянаж үзсэн үү, нийтлэлд гарч байгаа болон бусад хvмvvсээс мэдээллийнхээ талаар дахин лавлаж асуусан үү, хэрэв асуугаад үнэн гэдэг хариулт авсан бол яг хэнээс асуусан бэ гэдгийг сэтгvvлчээс тодруулна.

4. Нийтлэлд байгаа мэдээлэл нь үнэн зөв байвал:

- Энэ мэдээллийг олон нийт заавал мэдэх шаардлагатай байсан үү гэдгийг сэтгvvлчээс асууна. Энд жирийн иргэд болон олны танил, алдар цуутай хvмvvсийн ялгаа дахин гарч ирнэ. Олон нийт нэр алдартай хvмvvсийн талаар бvх зvйлийг заавал мэдэж байх албагvй. Ялангуяа ажил хэрэг, албан тушаалтай нь холбоотой зvйлээс бусдыг мэдэх шаардлагагvй. Энэ талаарх нийгмийн сэтгэхvй ч жил ирэх тусам өөрчлөгдсөөр байна. 40 жилийн өмнө манай улсад эхнэрээсээ салсан улс төрч огцрох шаардлагатай байдаг байсан бол одоо тийм биш болсон.

5. Тухайн нийтлэлд байгаа мэдээлэл нь нийгэмд хэр ач холбогдолтой болохыг шvvх анхаарч үзэх ёстой.

6. Ямар төрлийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр тухайн мэдээлэл цацагдсан бэ гэдгийг харж үзнэ.

- Хэрэв нэр хүндтэй, сайн сонин байвал сэтгvvлчийг нь арай өндөр түвшинд авч үзэх бөгөөд харин шар сонины сэтгvvлчийг өөр түвшинд авч үзнэ. Хэрвээ сэтгvvлч нийтлэлээ сонины ямар нэгэн буланд зориулж өөрийнхөө үзэл бодлоор бичсэн байвал мөн доогуур түвшинд, арай зөөлөн хэмжvvрээр авч үздэг. Хэрэв шvvхээс бичсэн нийтлэлийнх нь төлөө сэтгvvлчийг буруутгасан шийдвэр гарвал бас зарим зvйлийг анхаарч үзэх ёстой. Үүнд:
- Хэрэв сэтгvvлч сонин дээрээ залруулга, уучлалт гаргасан байвал хохирлын хэмжээг дахин хянаж үзэж болно.
- Тухайн нийтлэл гарсан сонин олон нийтэд хэр их хэмжээгээр тараагдсан бэ гэдгийг харгалзан үзнэ.
- Гомдол гаргагчийн нэхэмжилж байгаа мөнгө нь тухайн хэвлэл мэдээллийн байгууллагад хэрхэн нөлөөлж болох вэ гэдгийг шvvх мөн анхаарч үзэх ёстой. Сэтгvvлчид оногдуулсан торгууль нь тvvний ажиллаж байгаа олон нийтийн байгууллагын оршин тогтнох чадварыг унагаах хэмжээнд байж болохгvй.

Голландад нэр төр гутаасан асуудалтай холбогдсон хэргүүд ихэвчлэн иргэний журмаар шийдэгддэг. Энд эрvvгийн хэрэг үүсгээд, эрvvгийн журмаар шийдвэрлэх нь ховор байдаг. Аливаа нийтлэлээр хэн нэгний нэр төрийг гутаасан гэсэн зарга үүсэх юм бол зөвхөн нийтэлсэн хүнд л арга хэмжээ авна. Гэхдээ шvvхээс мөнгөн торгууль ногдуулдаг. Жишээлбэл, хэдэн жилийн өмнө манай улсад нилээд шуугиан тарьсан нэгэн хэрэг гарсан. Сэтгvvлч нийтлэлдээ бусдыг гэмт хэргийн шинжтэйгээр гvтгэсэн байсан ба шvvхээс тvvнд маш өндөр хэмжээний торгууль буюу 100 мянган ам. долларын торгууль оногдуулсан. Учир нь сэтгvvлч нийтлэлдээ нэгэн хотын дарга хүнийг авлигын хэрэгт орооцолдсон гэж ойлгогдохоор (гэхдээ шууд бусаар) бичсэн байсан. Энд хамгийн сонирхолтой нь,

хохирогч хэвлэл мэдээллийн талаар ямар ч туршлагагүй өмгөөлөгч авсан байсан бөгөөд тэр өмгөөлөгч нь ямар нэгэн аргаар уг хэргийг эрвүгийн журмаар шийдвэрлүүлэх талаар прокурорыг итгүүлж чадсан. Ер нь бол иймэрхүү хэргүүд ихэвчлэн иргэний шугамаар шийдэгддэг. Голландын иргэний хуулиар шүүх нь нэхэмжлэгчид учруулсан хохирлоо телж барагдуулахыг сэтгүүлчээс шаарддаг. Зарим улсад иймэрхүү тохиолдолд сэтгүүлчдэд өөр нэмэлт торгууль оногдуулдаг. Харин Голландад тийм биш.

Зарим шар сонин ямар нэгэн байдлаар гүтгэсэн шинжтэй нийтлэл биччихвэл илүү их ашиг олно гэж боддог. Зарим тохиолдолд бүр тийм зүйл бичсэнийхээ төлөө торгууль хүлээнэ гэдгээ ч мэдэж байдаг. Тийм учраас сониноо зараад олох ашиг, дараа нь шүүхэд төлөх зардлаа тооцоод үзчихсэн тохиолдол ч гардаг. Ийм нөхцөлд мэдээж энэ нь шүүгчийн л шийдвэрлэх асуудал юм. Шүүгч тэдний хийсэн энэ тооцоог олж мэдээд, дахин ийм явдал гаргуулахгүй байх хэмжээнд торгууль оногдуулах хэрэгтэй. Ийм нөхцөлд нэр төрөө сэргээлгэх гэж байгаа хүн нь хангалттай их мөнгө нэхэмжлэх хэмжээний хүн байх хэрэгтэй. Зарим тохиолдолд тухайн хүний нэр төрөө гутаалгаснаас болж амссан хохирол нь шүүхэд дуудагдсанаас хойш гарсан хохирлоос нь бага болчихдог. Өөрөөр хэлбэл, шүүхэд дуудагдсанаас хойш, өмгөөлөгч хөлслөх, унаа тэрэг хөлслөх гэх мэтээр гарах зардал нь зөвхөн сонинны нийтлэлээс болж учирсан хохирлын хэмжээнээс илүү болж, шүүхэд хандсанаар бүр их нэмэгддэг. Ийм нөхцөлд хохирлын хэмжээг урьдчилан сонинтойгоо тохирох хэрэгтэй болно. Үүнийг шүүхээс гадуур шийднэ.

Хэвлэл мэдээллийн талаарх бусад хязгаарлалт - улсын нууц, хувийн нууц гэх мэт

Европын шүүх нь улс орны дээд шатны шүүхүүд Европын хүний эрхийн конвенцийн 10-р зүйлийг зерчиж буй эсэхийг шалгадаг. Тэд ямар нэгэн торгууль, шийтгэл оногдуулдаггүй, харин дүгнэлт, зөвлөмж гаргадаг. Ер нь Европт сэтгүүлч хүнийг шоронд суулгах нь хүлээж авч болшгүй зүйл гэж үздэг.

Хувийн нууцтай холбоотой нэг жишээ хэлье. Хэдэн жилийн өмнө Голландад хил дамжсан нэгэн хэрэг гарсан байна. Энэ нь хэн нэг хүн Голландын алдартай бизнесмэнийг хулгайлаад, амь насыг нь хөнөөж, хуруугий нь гэр бүлд нь явуулсан хэрэг байжээ. Гэвч дараа нь цагдаагийн байгууллага тэр алуурчныг олж, ял тулгасан бөгөөд мөрдөн байцаалт явуулж байхдаа бизнесмэнийг хулгайлсан газар очсон байна. Тэр нь хохирогчийн гэрийн цэцэрлэг дотор байсан бөгөөд сэтгүүлчид мөн тэнд очиж сурвалжлага аваад, сонинд мэдээ гаргажээ. Гэхдээ гэмт хэрэгтний нүдийг нь хараар тагласан байв. Ингээд хэрэгтэн шийтгэгдэж шоронд орсон боловч тэр хэргийн талаар мэдээлэл гарсаар л байлаа. Харин сэтгүүлчид сүүлдээ нөгөө хүний зургийг гаргахдаа нүдийг нь таглалгүй гаргадаг болсон байна. Энэ үед гэмт хэрэгтэн юу ч хийж чадахгүй байсан бөгөөд тэгээд ч шоронд орчихсон учир үүнийг тоолгүй орхижээ. Гэтэл хэдэн жилийн дараа түүний зураг гэрэл зургийн уралдаанд шалгарч, сэтгүүлч нь шагнал авч, олон нийтийн өмнө дахиад л ямар ч халхавчгүй гарч ирсэн байна. Тэгэхээр нь нөгөө шоронд байгаа гэмт хэрэгтэн зарга үүсгэж, учирсан хохирлоо төлүүлэхээр шүүхэд ханджээ. Учир нь тэр өөрийнхөө хувийн нууцыг зерчигдсэн гэж үзсэн. Гэтэл шүүх хариуд нь: “Үгүй ээ, та урьд нь хийсэн гэмт хэргээрээ олонд алдартай болсон. Тэгээд ч хэдэн жилийн өмнө нь энэ зураг ямар ч халхавчгүй гарч байхад та юу ч хэлэлгүй, дуугүй өнгөрч байсан” гэж хэлээд “энэ бол гэмт хэрэгт сэжиглэгдэж байгаа хүн биш, олон нийтэд нэгэнт тодорхой болсон, ял эдэлж байгаа хүн учраас түүнд ямар ч хохирол байхгүй” гэж үзсэн байна. Энэ жишээнээс та бүхэн хувийн нууцтай холбоотой асуудлыг шүүх шийдэхдээ тал бүрийн тэнцвэрт байдлыг хэрхэн барьж байгааг харж болно.

“ОЛОН НИЙТИЙН ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН ХЭРЭГСЭЛ, ШҮҮХ ЭРХ МЭДЭЛ”